



## МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 14.40 минутанд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Самбуугийн гудамж, “Орон зай” төв 7 давхарт 702 тоотод болов.

Хуралд : Ч.Амарбаатар 3 323 000 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

С.Долоонбаяр 3 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/  
Таван толгой транс ХХК 3 532 125 ширхэг хувьцааны саналаар /төлөөлөл/  
Л.Түвшинжаргал 5 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр /  
Ж.Энхтунгалаг 15 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/  
Б.Энхтуяа 5 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/  
БИ ДИ СЕК 274 298 ширхэг хувьцааны саналаар /төлөөлөл /  
Н.Бурмаа 10 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/  
“ЭЭБС” ХХК 3220 ширхэг хувьцааны саналаар /төлөөлөл /

7 132 676 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 71.3 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох М.Отгонбаатар, П.Мөнхчулуун нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Амарбаатар удирдав.

Хурлаар:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
2. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
4. НШШГГ-д байгаа компанийн өр зээлийн асуудлыг хэлэлцэх;  
асуудлыг тус тус хэлэлцэв.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулъя. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 71.3 % хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 14.40 минутанд эхлэв.

#### СОНССОН НЬ :

ТУЗ-ийн дарга Ч.Амарбаатар: Бид компаний 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангай танилцахын чацуу цаашдын үйл ажиллагааны талаар хэлэлцэнэ. Ингээд та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг хүсэж байна.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг / Гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэ танилцуулав /
2. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг / ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Отгонбаатар танилцуулав /
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг / ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хараат бус гишүүн М.Отгонбаатар танилцуулав /
4. НШШГТ-д байгаа компанийн өр зээлийн асуудлыг хэлэлцэх; /Хурлын дарга Ч.Амарбаатар танилцуулав/

#### СОНССОН НЬ 1:

**Хурлын дарга Ч. Амарбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. Манай ХК нь 2017 онд санхүүгийн алдагдалтай ажилласан. Мөн ТУЗ болон хувьцаа эзэмшигчидийн хурал дээр Манай ХК-ийн эзэмшлийн “Монгол Шилтгээн” байгууламж болох хэрэмний гаднах түрээсийн гэрүүд хэрэмний доторхи бүхэлдээ Голомт банкны барьцаанд байгаа, бас НШШГТгазраас өрөө төл гэж байгаа тухай хэлж ярьж байсан Голомт банкнаас өрөө төл төлөхгүй бол шаардлагтай арга хэмжээг авна гэдэг Нямсүрэн гэдэг хүний гарын үсэгтэй бичиг ирсэн. Энэ асуудал шүүхээр орж шийдвэр гарсан. Одоо бид хамаг хөрөнгөө алдахад хүрээд байна. Манай томоохон хувьцаа эзэмшигчид үүнийг анхааралдаа авна уу. Би үндсэндээ энэ асуудлыг сүүлийн 2 жилийн хувьцаа эзэмшигчдийн хуралд дээр мөн ТУЗ-ийн хурал дээр ч удаа дараа ярьж байна. Ямар гарц, боломж байгааг судлах хэрэгтэй

байна. Энэ мөнгө Монгол шилтгээн ХК-д зарцуулагдаагүй. Мөн “Монгол фүүд” ХХК-тай ярилцаж уг байгууллагаас мөнгийг төлүүлэх талаар шийдвэр гаргуулах хэрэгтэй байна. Нэмж хэлэхэд “Голомт” банкны хурлын шийдвэрийг хүлээж байна.

**П.Мөнхчулуун:** Банкны өрийн талаар их ярилцдаг. “Монгол Шилтгээн”-ийг өрийн барьцаанд тавьсан ч “Монгол Шилтгээн”-д оруулсан хөрөнгө оруулалт байдаггүй. Өрийн барьцаанд тавьсан компанийн үүсгэн байгуулагч С.Отгонбаатар болно бүтнэ л гэж ярьдаг. Бид нэг их хөрөнгөтэй харагддаг. Гэвч үнэн чанартаа үгүй юм. Өрийн барьцаанд тавьсан С.Отгонбаатар ТУЗ-ын хуралд ч ХЭХуралд ч ирдэггүй. Иймд өөрийн санаагаа хэрэгжүүлж ажиллах нь зөв гэж бодож байна.

**А.Ариунсайн:** Би хэд хэдэн удаа ТУЗ-ийн гишүүн С.Отгонбаатартай уулзсан өөрөө ТУЗ-өөсөө гарий гэж хэлсэн КТХуулийнд 5 дээш хувийн хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь 3 сарын 1-ны дотор хэлэлцэх асуудалд санал оруулж болно гэсэн заалтын дагуу хувьцаа эзэмшигч Ч.Амарбаатарын санал болгосоноор шинээр компанийн төлөөлөн удирдах зөвлөлд Л.Ариунболд орж ирж байгаа та нар Монгол базалт гэдэгээр нь сайн мэдэх байх.

**Ж.Энхтунгалаг:** Хурлын дарга Ч.Амарбаатар таныг өөрийн санаагаа хэрэгжүүлж ажилласан нь дээр гэж үзэж байна. Шүүх болон ШШГажилд тусалж дэмжиж ажиллахад бэлэн байгаа гэдгээ илэрхийлье. Хэвлэлийн бага хурал зохион байгуулж өгч болно шүү.

**Б.Энхтөр:** Ч.Амарбаатарын үгийг сонслоо. Гүйцэтгэх захирал Ган-Эрдэнийн үгийг сонсоё. Мөн энэ асуудал нэг талаас нь харвал боломж байж болох юм. Ер нь Монгол шилтгээнд газар үлдэж байгаа юу. Би танай тухай мэдээллийг н.Отгонбаатараас авдаг.

**Н. Ган-Эрдэнэ:** Манайх улиралын чанартай ажилладаг. Хавар, намартаа ажиллах гэхээр байрны дулааны асуудлаас болоод ажиллаж чаддаггүй. Дулааны асуудлыг шийдэхэд их мөнгөний асуудал яригдаж байна. Ер нь бол манай барилгуудыг зассанаас шинийг барьсан нь дээр болоод байна. Элэгдэлд их орсон байгаа. Нэг хөлдөөд нэг гэсээд байхаар элдэгдэл хорогдол маш их гардаг мөнтүүнчлэн хаврын хонхны баяр, намрын олон найр хурмыг бид авч чадахгүй байгаа.

Байхгүй бол саналаа өгөөд хурлаа завсарлах уу.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:1

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2017 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:2

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.  
Ч.Амарбаатар  
Д.Давгадорж  
С.Отгонбаатар  
Г.Ганчимэг  
Д.Ганболд  
М.Ган-Эрдэнэ
2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.  
П.Мөнхчулуун  
Г.Мөнхбилэг  
М.Отгонбаатар
3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:3

1. Компанийн үйл ажиллагааг сайжруулж ашиг орлогыг нэмэгдүүлэх үүднээс доорхи ажилуудыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Амарбаатарт даалгасугай.

Үүнд:

- Компанийн хөгжлийн концепцийг хөгжлийн шинэ эрин үетэй нийцүүлэн боловсруулах
- Компанийн үйл ажиллагааг жилийн 4 улирал болгох
- Усан парк байгуулах зураг төслийг боловсруулах

гэрээний үүргээ зөрчсөн, компанид хохирол учруулсан, хувьдаа ашигласан үйлдлүүдийг эрүү болон иргэний хэргийн шүүхээр тогтоолгох нэхэмжлэл, гомдол гаргах

- Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.4-д заасны дагуу өөрийн буруугаас компанид хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтан буюу С. Отгонбаатараар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хариуцлага хүлээлгэх
- “Монгол Фүүд” ХХК-тай холбоотой үл хөдлөх хөрөнгө, хувьцааны талаар судалж тогтоох
- Голомт банкны өрийг хувьцаагаар сольж компанийн хувьцаа эзэмшигч болгох замаар компанийн хөрөнгийг барьцаанаас чөлөөлүүлэх боломжийг судлах, хэлэлцээ хийх

2. Шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулж, мэдээллээр хангах ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга / А.Ариунсайн/-д үүрэг болгосугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 17 цаг 10 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

/Ч.АМАРБААТАР/

/ А.АРИУНСАЙН /